



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Улаанхус, Бугат сумд, Цагааннуур тосгоны хил орчмын бүс нутагт хийх тарваган тахал өвчний хамтарсан тандалт судалгаа”-ны ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Халдвар судлагч (Ц.Отгонцэцэг)-д, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Х.Ариунболд)-д үүрэг болгосугай.

2. Тандалт судалгааны зардал болох 11,100,000 (арван нэгэн сая нэг зуун мянган) төгрөгийг томилолт, тээвэр, шатахуун, холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

Disk E/2025/Zakhirliin tushaal A

• 1913171609